СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# ТҮҮХЭН ЗАМНАЛ

1988 БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1988 оны 148 дугаар тогтоолоор Музей удирдах газрын харьяанд "Музейн үзмэр сэргээн засварлах урлан" нэртэйгээр байгуулагдсан.

1990 Монгол Улсын Соёлын сайдын 1990 оны 130 дугаар тушаалаар "Музейн үзмэр сэргээн засварлах урлан" бие даасан байгууллага болсон

1995-1996 Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 238 дугаар тогтоол, Соёлын сайдын 1996 оны 07 дугаар тушаалаар тус урлангийн бүтэц, орон тоог өргөтгөж, түүх, соёлын дурсгалт зүйлийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүргийг нэмж, "Соёлын өвийн төв" болон өөрчлөн зохион байгуулагдсан.

2008 Засгийн газрын 2008 оны 302 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 47 дугаар тушаалаар тус төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, соёлын биет бус өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүрэг нэмэгдсэн.

2017 Засгийн газрын 2017 оны 239 дүгээр тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/295 тоот тушаалаар "Соёлын өвийн үндэсийн төв" болон өөрчлөгдөж, байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиг үүрэг өргөжсөн.

# СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

## АЛСЫН ХАРАА

“Соёлын өвийн олон улсын хамтын ажиллагааны Монгол дахь салбар төв” болох.

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол үндэстэн, угсаатны соёлын өвийн үнэ цэнэ, орон зайн дархлааг бид хадгалан хамгаалж, ирээдүйд өвлөн үлдээнэ.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН

# СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, СУДАЛГААНЫ ГАЗАР

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

## АГУУЛГА


**1. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН, ТОГТОЛЦОО**

**2. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, СУДАЛГААНЫ ГАЗАР**

**3. ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ЛУРСГАЛЫН БҮРТГЭЛИЙН ТОО БАРИМТ**

- **Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн, төрөл зүйлийн үзүүлэлт**
- **“Улсын” болон “Аймаг, нийслэлийн” хамгаалалтад байх үл хөдлөх дурсгалын тоо,**
- **“Сум, дүүргийн” хамгаалалтад байх үл хөдлөх дурсгалын тоо.**
- Засгийн газрын тогтоолоор хамгаалалтын бүс тогтоогдсон үл хөдлөх дурсгалт газар,
- **Улсын тусгай хамгаалалттай газар нутагт орших буй дурсгалын тоон үзүүлэлт.**

**4. ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛИЙН ТОО БАРИМТ**

- Улс, аймаг, орон нутгийн музей, сумдын орон нутаг сурталчлах танхим, эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургууль, Үндэсний номын сан, Эрдэнэсийн сан, сүм хийд зэрэг нийт байгууллага, нэгжид хадгалагдаж буй хөдлөх дурсгалт зүйлийн тоон дүн, төрөл зүйлийн үзүүлэлт,
- Түүх, соёлын “хосгүй үнэт” зэрэглэлийн дурсгалт зүйлийн тоо.

**5. СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ(СББӨ) –ИЙН БҮРТГЭЛИЙН ТОО БАРИМТ**

- СББӨ-ийн бүртгэлийн тоон дүн, хамаарах ай сав,
- СББӨ-ийг өвлөн уламжлагчийн тоон дүн, хамаарах ай сав,
- Дэлхийн өвд бүртгэгдсэн монголын соёлын биет бус өв.

**6. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ**

## 1. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

(Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн Соёлын өвийн бүртгэлийн тухай 4 дүгээр бүлгийн 20; 20.1; 20.2; 20.3; 20.4; 20.5; 20.6-р зүйл)

| Бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо | Тогтолцооны дагуу БМСанг бүрдүүлэгч субъект | Тухайн БМСанд бүрдүүлэх соёлын өвийн бүртгэл, мэдээлэл |
|---|---|---|
| • байгууллагын бүртгэл, мэдээллийн сан | - Улс, аймаг орон нутгийн музей,<br>- Үндэсний номын сан,<br>- Эрдэм шинжилгээний хүрээлэн, судалгааны лаборатори,<br>- Монгол банкны Эрдэнэсийн сан,<br>- Сүм хийд, | Тухайн байгууллагын өмчлөл, эзэмшил дэх:<br>- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл |
| | - Дурсгалт газрын хамгаалалтын захиргаа. | Тухайн хамгаалалтын бүс дэх соёлын өвийн бүртгэл, мэдээлэл |
| • сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан | - Соёлын төвд, | Харъяалах баг, хорооны нутаг дэвсгэр дэх<br>- Түүх соёлын үл хөдлөх дурсгал,<br>- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл,<br>- Соёлын биет бус өв |
| • аймаг,<br>• нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан | - Орон нутгийн музей,<br>- Нийслэлийн Засаг даргын дэргэдэх соёлын асуудал хариуцсан нэгжид | Харъяалах сум, дүүргийн нутаг дэвсгэр дэх:<br>- Түүх соёлын үл хөдлөх дурсгал,<br>- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл,<br>- Соёлын биет бус өв |
| • Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан | - Соёлын өвийн үндэсний төв | 21 аймаг, нийслэл дэх :<br>- Түүх соёлын үл хөдлөх дурсгал,<br>- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл,<br>- Соёлын биет бус өв |

# 2. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, СУДАЛГААНЫ ГАЗАР

(Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн Соёлын өвийн бүртгэлийн тухай 4 дүгээр бүлгийн 20.1.4; 20.2; 20.3; 20.7; 20.8; 20.9; 20.10дугаар зүйл)

**СӨБСГазрын чиг үүрэг:**

- Соёлын өвийг эрэн сурвалжлах, таньж тогтоох, тодорхойлох, бүртгэх, баримтжуулж улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх;
- Шат, шатны бүртгэл, мэдээллийн санг арга  зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
- Өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрөл, холбогдох журмын дагуу соёлын өвийг олон нийтэд сурталчлах, сурталчилгааны бүтээл гаргах;
- Эрх бүхий төрийн байгууллагуудыг соёлын өвийн лавлагаа, мэдээллээр шуурхай хангах, иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн соёлын өвийн лавлагаа мэдээллийг гаргаж өгөх;
- Гадаад улс оронд хадгалагдаж байгаа монголын түүхэнд холбогдох соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх;
- Соёлын өвийн ангилал, төрөл зүйлээр статистик, мэдээлэл гаргах, тоо бүртгэл хөтлөх.

**Орон тоо:** 2021 оны I улирлын байдлаар СӨБСГазар 8 хүний орон тоотой ажиллаж байна. Үүнд:

- СӨБСГазрын дарга -1 хүн,
- Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч – 1 хүн,
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгал хариуцсан бүртгэл, мэдээллийн санч -2 хүн,
- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хариуцсан бүртгэл, мэдээллийн санч -1 хүн
- Соёлын биет бус өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч -2 хүн
- Соёлын биет бус өв хариуцсан шинжээч -1 хүн

# 3. ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН БҮРТГЭЛИЙН ТОО БАРИМТ

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1-д заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/108 дугаар тушаалаар түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын үзлэг, тооллого улсын хэмжээнд анх удаа 2015 онд зохион байгуулагдсан.
- Тус үзлэг тооллогоор 21 аймаг, нийслэлийн 330 сум, 9 дүүргийн нутаг дэвсгэр дэх 9537 дурсгалт газрын 86157 үл хөдлөх дурсгал тоологдож бүртгэгдсэн.

| Аймгийн нэр | Чулуун зэвсгийн дурсгалт газар | Хадны зураг, бичгийн дурсгал | | Булш оршуулгын дурсгал | | Тахил тайлгын байгууламж | | Барилга, архитектурын дурсгал | | Хөшөө дурсгал | | Үйлдвэрлэлийн үл мөр хадгалсан дурсгалт газар | Палеонтологийн дурсгалт газар | Нийт дурсгалт газар | Нийт дурсгал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ДГ | Д | ДГ | Д | ДГ | Д | ДГ | Д | ДГ | Д | | | | |
| Архангай | | 37 | 23 | 92 | 2674 | 32 | 65 | 42 | 125 | 111 | 142 | | | 314 | 3029 |
| Баян-Өлгий | 36 | 26 | 29 | 432 | 4018 | 71 | 443 | | | 259 | 624 | | | 824 | 5150 |
| Баянхонгор | 7 | 48 | 5320 | 99 | 1767 | 74 | 172 | 50 | 115 | 79 | 162 | 3 | 2 | 362 | 7548 |
| Булган | 2 | 139 | 165 | 205 | 2645 | 15 | 16 | 52 | 52 | 99 | 177 | 1 | | 513 | 3058 |
| Говь-Алтай | 3 | 90 | 105 | 821 | 5131 | 61 | 80 | 42 | 45 | 113 | 261 | 1 | 3 | 1134 | 5629 |
| Говьсүмбэр | | 1 | 1 | 33 | 284 | 8 | 8 | 5 | 5 | 8 | 8 | | | 55 | 306 |
| Дархан-Уул | | 5 | 5 | 20 | 318 | 2 | 3 | 23 | 23 | 3 | 5 | | | 53 | 354 |
| Дорноговь | 1 | 35 | 46 | 166 | 750 | 99 | 111 | 96 | 1597 | 13 | 18 | 3 | 18 | 431 | 2544 |
| Дорнод | 10 | 4 | 7 | 108 | 2020 | 18 | 103 | 92 | 117 | 17 | 40 | 2 | | 251 | 2299 |
| Дундговь | 2 | 36 | 37 | 151 | 1392 | 63 | 65 | 44 | 44 | 6 | 7 | 1 | 3 | 306 | 1551 |
| Завхан | | 93 | 101 | 314 | 6995 | 113 | 616 | 34 | 36 | 175 | 1186 | | | 729 | 8934 |
| Орхон | | | | 28 | 343 | | | 5 | | 6 | 11 | | | 39 | 354 |
| Өвөрхангай | 4 | 50 | 118 | 314 | 6165 | 70 | 147 | 57 | 60 | 60 | 114 | 7 | 4 | 566 | 6619 |
| Өмнөговь | 1 | 51 | 51 | 43 | 2148 | 24 | 24 | 62 | 62 | 13 | 13 | 3 | 16 | 213 | 2318 |
| Сүхбаатар | 27 | 21 | 20 | 97 | 1157 | 42 | 42 | 50 | 63 | 39 | 97 | 1 | | 277 | 1407 |
| Сэлэнгэ | 4 | 20 | 44 | 240 | 2861 | 3 | 3 | 25 | 35 | 47 | 52 | 4 | | 343 | 3003 |
| Төв | | 21 | 178 | 227 | 2895 | 43 | 1397 | 71 | 106 | 26 | 92 | 1 | | 389 | 4669 |
| Увс | | 79 | 86 | 162 | 1573 | 17 | 17 | 4 | 6 | 202 | 395 | 0 | 1 | 464 | 2077 |
| Ховд | - | 92 | 307 | 305 | 5947 | 61 | 237 | 35 | 35 | 88 | 484 | 3 | 5 | 589 | 7018 |
| Хөвсгөл | 2 | 72 | 91 | 485 | 10721 | 23 | 34 | 25 | 24 | 91 | 207 | 2 | | 700 | 11081 |
| Хэнтий | 32 | 58 | 59 | 551 | 5776 | 113 | 580 | 124 | 148 | 104 | 132 | 3 | | 985 | 6730 |
| Улаанбаатар | | 3 | 3 | 60 | 347 | 5 | 4 | 146 | 122 | 3 | 3 | | | 217 | 479 |
| **Нийт дурсгалт газар** | | **981** | | **4953** | | **957** | | **1084** | | **1562** | | | | **9537** | |
| **Нийт дурсгал** | **131** | | **6796** | | **67927** | | **4167** | | **2820** | | **4230** | **35** | **51** | | **86157** |

ДГ- Дурсгалт газар
Д- Дурсгал

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# СОЁЛЫН ӨВИЙН УЛСЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭГДСЭН 9537 ДУРСГАЛТ ГАЗРЫН 86157 ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ /төрөл зүйлийн ангиллаар/



## СӨУНБМСанд 2017-2019 онд нэмж 3406 үл хөдлөх дурсгал бүртгэгдсэн байна.

| Он | Архангай | Баян-Өлгий | Баянхонгор | Булган | Говь-Алтай | Говь-сүмбэр | Дархан-Уул | Дорноговь | Дорнод | Дундговь | Завхан | Орхон | Өвөрхангай | Өмнөговь | Сүхбаатар | Сэлэнгэ | Төв | Увс | Ховд | Хөвсгөл | Хэнтий | Улаанбаатар | ШУА-н Түүх, археологийн хүрээлэн | Дэлхийн өв-ОХСДГХЗ | ШУА-н Палеонтологийн төв | Монголын үндэсний музей | Улаанбаатарын Их сургууль | Ховд Их сургууль | НСИСОУ-ын хүрээлэн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2017 (Д) | - | - | 2 | 6 | 14 | 1 | - | - | - | - | 104 | - | 144 | 10 | 11 | - | - | - | 105 | 30 | 49 | - | - | - | - | 526 | 184 | 19 | - |
| 2018 (Д) | - | - | - | - | 83 | 11 | - | - | - | - | - | - | - | - | - | - | 2 | - | - | - | - | - | - | 6 | - | 23 | 302 | 336 | - |
| 2019 (Д) | 14 | - | 7 | - | - | 3 | - | - | - | - | 41 | 3 | 20 | 45 | 312 | - | 4 | 14 | 47 | 1 | 2 | - | 1438 | - | 9 | 352 | - | 58 | 2 |

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

## 2020 онд Аймаг, нийслэлийн БМСанд шинээр бүртгэсэн үл хөдлөх дурсгалын тоон дүнгийн график үзүүлэлт



2021 оны 5 дугаар сарын байдлаар СӨУНБМСанд 9754 дурсгалт газрын 90043 ширхэг түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүртгэлтэй байна.

| № | Үзүүлэлт | Дурсгалт газар | Дурсгал |
|---|---|---|---|
| 1 | 2015 оны түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогын дүн | 9537 | 86157 |
| 2 | 2017-2019 онд нэмж бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн | - | 3406 |
| 3 | 2020 онд нэмж бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн | 217 | 480 |
| | **СӨУНБМСанд бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн (2021 оны 5 дугаар сарын байдлаар)** | **9754** | **90043** |

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# 2020 онд гэмтсэн, тоногдсон, зөөгдсөн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн

| № | Аймаг, нийслэл | Гэмтсэн дурсгал | Тоногдсон дурсгал | Зөөгдсөн дурсгал | **Нийт** |
|---|---|---|---|---|---|
| 1 | Баянхонгор | | 1 | | **1** |
| 2 | Булган | | | 1 | **1** |
| 3 | Говь-Алтай | | 3 | | **3** |
| 4 | Дорноговь | | 75 | | **75** |
| 5 | Дундговь | | 20 | | **20** |
| 6 | Сүхбаатар | | | 2 | **2** |
| 7 | Төв | | | 1 | **1** |
| 8 | Хөвсгөл | | 1 | | **1** |
| 9 | Хэнтий | | 4 | | **4** |
| 10 | Нийслэл | 3 | | | **3** |
| | Нийт | **3** | **104** | **4** | **111** |

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# Эрдэм шинжилгээний байгууллагуудын 2020 онд авран хамгаалах ажлаар илрүүлсэн үл хөдлөх дурсгалын тоон үзүүлэлт



# Эрдэм шинжилгээний байгууллагуудын 2020 онд авран хамгаалах ажлаар илрүүлсэн үл хөдлөх дурсгалын төрөл зүйлийн үзүүлэлт



(Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн Засгийн газрын бүрэн эрхийн тухай 13.1.7 дугаар зүйл, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн тухай 14.1.5 дугээр зүйл)

## УЛС, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХАМГААЛАЛТАД БАЙХ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ЖАГСААЛТ

- Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор “Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д **182** дурсгал,
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/161 дугаар тушаалын хавсралт “Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д **607** дурсгал тус тус бүртгэгдсэн.

| Хамгаалалтын ангилал | Архангай | Баян-Өлгий | Баянхонгор | Булган | Говь-Алтай | Говь-сүмбэр | Дархан-Уул | Дорноговь | Дорнод | Дундговь | Завхан | Орхон | Өвөрхангай | Өмнөговь | Сүхбаатар | Сэлэнгэ | Төв | Увс | Ховд | Хөвсгөл | Хэнтий | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Улсын | 18 | 13 | 12 | 12 | 8 | - | 1 | 4 | 3 | 6 | 6 | 1 | 13 | 11 | 7 | 2 | 17 | 6 | 9 | 8 | 12 | 13 |
| Аймаг, нийслэлийн | 39 | 33 | 54 | 41 | 33 | 3 | 2 | 27 | 31 | 37 | 23 | - | 72 | 35 | 24 | 23 | 24 | 10 | 18 | 31 | 33 | 14 |

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

## УЛСЫН ХАМГААЛАЛТАД БАЙХ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТООН ҮЗҮҮЛЭЛТ (ДУРСГАЛЫН ТОО)

- Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор “Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д орсон **182** дурсгал (аймаг, нийслэлээр)



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

## АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХАМГААЛАЛТАД БАЙХ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ТООН ҮЗҮҮЛЭЛТ (ДУРСГАЛЫН ТОО)

- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/161 дугаар тушаалын хавсралт “Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д орсон **607** дурсгал (аймаг, нийслэлээр)



## СУМ, ДҮҮРГИЙН ХАМГААЛАЛТАД БАЙХ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ЖАГСААЛТ

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15.2 дугаарт зүйл: "...Мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг баталж, хилийн зааг, хамгаалалтын дэглэмийг тогтоон хяналт тавина." гэж заасны дагуу 2020 оны 12 дугаар сарын байдлаар Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Сүмбэр, Орхон, Төв, Увс зэрэг 7 аймгийн ИТХ-аас харьяалах нутаг дэвсгэрийнхээ "Сум, дүүргийн хамгаалалтад байх үл хөдлөх дурсгалын жагсаалт"-ыг баталжээ.

Уг жагсаалтад дээрх 7 аймгийн нийт 1496 дурсгалт газар, 11123 дурсгал орсон байна.

Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Улаанбаатар зэрэг 12 аймаг, нийслэлийн ИТХ-аас "Сум, дүүргийн хамгаалалтад байх үл хөдлөх дурсгалын жагсаалт"-аа баталгаажуулаагүй байна.

| № | Аймаг, нийслэл | Сум, дүүрэг | Дурсгалт газар | Дурсгал | Эрх зүйн чадамжтай |
|---|---|---|---|---|---|
| 1 | Архангай | 19 | 266 | 2279 | Аймгийн ИТХ-ын тогтоол |
| 2 | Баян-Өлгий | 11 | 506 | 4141 | Аймгийн ИТХ-ын тогтоол |
| 3 | Булган | 16 | 137 | 1130 | Аймгийн ИТХ-ын тогтоол |
| 4 | Говьсүмбэр | 3 | 48 | 273 | Аймгийн ИТХ-ын тогтоол |
| 5 | Орхон | 2 | 18 | 111 | Аймгийн ИТХ-ын тогтоол |
| 6 | Төв | 22 | 79 | 1127 | Аймгийн ИТХ-ын тогтоол |
| 7 | Увс | 19 | 442 | 2062 | Аймгийн ИТХ-ын тогтоол |
| Нийт | 7 | 92 | 1496 | 11123 | Аймгийн ИТХ-ын шийдвэрээр сум дүүргийн хамгаалалтад орсон байна. |

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# ХАМГААЛАЛТЫН БҮС ТОГТООГДСОН ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ГАЗРУУД

(Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн Засгийн газрын бүрэн эрхийн тухай 13.1.12 дугаар зүйл)

- Засгийн газрын 12 удаагийн тогтоол шийдвэрээр үл хөдлөх 36 дурсгалт газарт хамгаалалтын бүс тогтоогдсон байна.

| № | ЗГ-ын тогтоолын огноо, дугаар | д/д | Хамгаалалтын бүс тогтоогдсон дурсгалын нэр | Хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 1997.12.15 -ны 241 дүгээр | 1 | Монголын эртний нийслэл Хархорум хотын туурь | 9,69 ам. дөр.км |
| 2 | 2001.4.25-ны 96 дугаар | 2 | Гандантэгчинлэн хийд, Гэсэр сүм | 58,0 га, |
| | | 3 | Богд хааны Ногоон ордон | 5,7 га, |
| | | 4 | Чойжин ламын сүм | 2,0 га |
| | | 5 | Дамбадаржаа хийд | 10,5 га |
| | | 6 | Гэр хэлбэрт модон дуганууд буюу Дашчойлин хийд | 1,7 га |
| | | 7 | Чин ван Ханддоржийн байшин | 0,5 га |
| 3 | 2002.4.17-ны 71 дугаар | 8 | Билгэ хаан | 20.8 кв.км |
| | | 9 | Культегин | |
| | | 10 | Хар балгас | 39.8 кв.км |
| | | 11 | Төвхөн хийдийн | 4.5 кв.км |
| | | 12 | Тоньюкук | 65.58 кв.км |
| 4 | 2003.8.27-ны 190 дүгээр | 13 | Уушгийн өврийн буган чулууны цогцолбор | 42,0 га, |
| | | 14 | Аваргын балгас | 1230 га |
| | | 15 | Манзуширийн хийд | 15,6 га |
| | | 16 | Дарь-Эхийн сүмийн 2 чулуун багана | 0,07 га |
| 5 | 2004.5.26-ны 126 дугаар | 17 | Хархорин сум, Баруун хүрээний туурь | 220 га |
| | | 18 | Хөгнө тарнийн дээд, доод хийдийн туурь | 42.9 га |
| 6 | 2004.12.1-ний 230 дугаар | 19 | Алтан-Өлгий дэх оршуулгын газар | |
| 7 | 2006.4.5-ны 70 дугаар | 20 | Цогт тайжийн цагаан байшингийн балгас, Бичигт хөшөө, Хар Бухын балгас | 920 га, 1080 га |
| 8 | 2006.5.31-ний 123 дугаар | 21 | Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газар | 121967 га |
| 9 | 2009.4.29-ний 135 дугаар | 22 | Эргэлийн зоон палеонтологийн дурсгалт газар | |
| | | 23 | Өнгөтийн цогцолбор дурсгал | |
| | | 24 | Их Хөшөөтийн цогцолбор дурсгал | |
| | | 25 | Өглөгчийн хэрэм | |
| | | 26 | Рашаан хад, Үзүүр цохионы цогцолбор дурсгал, | |
| | | 27 | Балдан Бэрээвэн хийд, түүний орчмын хадны зургийн дурсгал | |
| | | 28 | Дунд Жаргалантын цогцолбор дурсгал | |
| | | 29 | Цэцэн ханы ордны цогцолбор | |
| | | 30 | “Өндөр хоршоо” хэмээх түүхт барилга | |
| | | 31 | Ардын Намын Төв Хороо, Ардын Засгийн газар түр байрлаж байсан түүхт барилга | |
| 10 | 2011.9.7-ны 271 дүгээр | 32 | Майхан уулын эртний нүүдэлчний язгууртны бунхант булш | 700 га |
| 11 | 2012.4.4-ний 104 дүгээр | 33 | Ноён уулын Сүжигтийн ам, Батсүмбэр сумын Ноён уулын Зурамт, Хужиртын ам, | 133.6 га |
| | | 34 | Балгасын талын Хүннүгийн язгууртны цогцолбор дурсгал | |
| 12 | 2013.12.14-ний 414 дүгээр | 35 | Шар цавын үлэг гүрвэлийн мөр бүхий дурсгалт газар | 408 га |
| | | 36 | Сүйхэнтийн чулуужсан мод бүхий дурсгалт газар | 892 га |

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн Тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллын тухай 3 дугаар зүйлд заасан: 1/ дархан цаазат газар; 2/ байгалийн цогцолборт газар; 3/ байгалийн нөөц газар; 4/ дурсгалт газарт нийт 4848 үл хөдлөх дурсгал орших байна.

**Улсын тусгай хамгаалалттай газар нутаг"-т орших буй 4848 дурсгалын тоон үзүүлэлт /аймаг, нийслэлээр/**



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# 4. ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛИЙН ТОО БАРИМТ

**2006 оноос хойш 3 удаа зохион байгуулагдсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогын дүн мэдээний хураангуй**

<table>
<tr><th rowspan="2">Улсын тооллого явагдсан хугацаа</th><th rowspan="2" colspan="2">Хамрагдсан байгууллага, too</th><th colspan="2">Тоологдсон үзмэр, эд өлгийн зүйлийн тоо</th></tr>
<tr><th>Дэс</th><th>Тоо ширхэг</th></tr>
<tr><td>2006-2008 оны музейн сан хөмрөгийн улсын тооллого</td><td>Улсын болон аймаг, орон нутгийн музей</td><td>35</td><td></td><td>206109</td></tr>
<tr><td rowspan="4">2012-2014 оны музейн сан хөмрөгийн улсын тооллого</td><td>Улсын музей-16</td><td rowspan="4">300</td><td rowspan="3">116477</td><td rowspan="3">258132</td></tr>
<tr><td>Аймаг, орон нутгийн музей-24</td></tr>
<tr><td>Сумдын ОНСТ-257</td></tr>
<tr><td>Сүм хийд-3<br>Гандантэгчэнлин хийд</td><td>8333</td><td>46064</td></tr>
<tr><td rowspan="4">2018-2019 оны түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллого</td><td>Улсын музей, байгууллага-19</td><td rowspan="4">307</td><td rowspan="4">126810</td><td rowspan="4">276077</td></tr>
<tr><td>Аймаг, орон нутгийн музей-24</td></tr>
<tr><td>Сумдын ОНСТ-261</td></tr>
<tr><td>Сүм хийд-3</td></tr>
</table>

# 4. ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛИЙН ТОО БАРИМТ

## 2018-2019 онд зохион байгууллагдсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогын тоон дүн

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн соёлын өвийн үзлэг, тооллого тухай 26.1 дүгээр заалт, Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам", Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/648 дугаартай "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай" тушаалд тус, тус заасны дагуу түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллого 21 аймаг, нийслэлийн хэмжээнд 2018 оны 11 дүгээр сарын 1-ээс 2019 оны 3 дугаар сарын 31-нийг хүртэлх хугацаанд зохион байгуулагдаж, төрийн өмчийн- 19, орон нутгийн өмчийн- 285, шашны өмчийн- 3, нийт 307 байгууллага, аж ахуйн нэгж хамрагдсан.

| № | 2018-2019 оны түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогод хамрагдсан | | Өмчийн хэлбэрээр |
|---|---|---|---|
| | Байгууллага | Байгууллагын тоо | |
| 1 | Улсын музей | 10 | Төрийн өмчийн (19) |
| 2 | Эрдэм шинжилгээний хүрээлэн | 2 | |
| 3 | Их, дээд сургууль | 3 | |
| 4 | Байгууллагын дэргэдэх музей | 3 | |
| 6 | Үндэсний номын сангийн ховор номын фонд | 1 | |
| 7 | Аймаг, орон нутаг, нийслэлийн музей | 24 | Орон нутгийн өмчийн (285) |
| 8 | Сум, дүүргийн Орон нутаг сурталчлах танхим | 261 | |
| 10 | Бурханы шашны сүм хийд | 3 | Шашны өмчит (3) |
| | **Нийт** | **307** | |

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ

# 2018-2019 онд зохион байгуулагдсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогын тоон дүн

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 оны улсын тооллогоор **127264 дэсийн 277019 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл тоологдохоос 126810 дэсийн 276077 ширхэг 105.659. 865,196 төгрөгийн үнэ** бүхий түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл тоологдсон байна.

| № | Улсын тооллогод хамрагдсан байгууллага-(307) | Тоологдох хөдлөх дурсгалт зүйл | | Дутсан | | Хулгайд алдсан | | Солигдсон | | Гадаадад үзэсгэлэнд | | Тоологдсон хөдлөх дурсгалт зүйл | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэс | тоо/ш | дэс | тоо/ш | дэс | тоо/ш | дэс | тоо/ш | дэс | тоо/ш | дэс | тоо/ш |
| 1 | Улсын музей-10, э/ш хүрээлэн-2, номын сан-1, их сургууль-3, сум хийд-2 | 59331 | 132270 | 9 | 9 | | | 1 | 1 | 19 | 67 | 59302 | 132193 |
| 2 | Аймаг, орон нутаг, нийслэлийн музей-24, байгууллагын музей-3 | 48205 | 109622 | 68 | 86 | 2 | 2 | 21 | 23 | | | 48114 | 109511 |
| 3 | Сум, дүүргийн ОНСТ-261, сум хийд-1 | 19728 | 35127 | 285 | 672 | 41 | 72 | 8 | 10 | | | 19394 | 34373 |
| | **НИЙТ ДҮН** | **127264** | **277019** | **362** | **767** | **43** | **74** | **30** | **34** | **19** | **67** | **126810** | **276077** |

- 15 аймгийн 87 сумын Орон нутаг сурталчлах танхим,
- Аймаг, орон нутгийн 6 музей,
- Улсын 4 музей,
- байгууллагын харьяа 1 музей,
- 1 сүм хийд зэрэг нийт **99** байгууллагын **146,529,941 төгрөгийн үнэ** бүхий нийтдээ **435 дэсийн 875 ширхэг** хөдлөх дурсгалт зүйл "дутсан", "хулгайд алдсан", "солигдсон" шалтгаанаар тоологдоогүй байна.

# 2018-2019 оны улсын тооллогод хамрагдсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн үнийн дүн

| № | Байгууллага болон Аймаг | Бүртгэлийн үнэ |
|---|---|---|
| 1 | Монголын үндэсний музей | 3,835,854,160 |
| 2 | Байгалийн түүхийн музей | 401,636,629 |
| 3 | Богд хааны ордон музей | 14,371,586,598 |
| 4 | Дүрслэх урлагийн музей | 26,773,960,500 |
| 5 | Монголын Театрын музей | 776,259,020 |
| 6 | Монголын Уран зургийн галерей | 15,073,161,407 |
| 7 | Хархорум музей | 3,243,061,013 |
| 8 | Хөшөө цайдам музей | 134,750,000 |
| 9 | Чойжин ламын сүм музей | 3,907,851,930 |
| 10 | Монголын Үндэсний номын сангийн үнэт ховор номын фонд | 2,974,884,400 |
| 11 | ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэн | 2,171,945,000 |
| 12 | Улаанбаатар хотын музей | 486,192,800 |
| 13 | Төрийн Түүхийн музей | 3,407,292,940 |
| 14 | Үлэг гүрвэлийн төв музей | 798,800,000 |
| 15 | Монгол цэргийн музей | 1,739,899,651 |
| 16 | Архангай аймаг (аймгийн музей ба 20 сумын ОНСТ) | 1,089,920,838 |
| 17 | Баян-Өлгий аймаг (аймгийн музей ба 9 сумын ОНСТ) | 1,569,178,350 |
| 18 | Баянхонгор аймаг (аймгийн музей ба 18 сумын ОНСТ) | 888,466,985 |
| 19 | Булган аймаг (аймгийн музей ба 16 сумын ОНСТ) | 141,705,500 |
| 20 | Говь-Алтай аймаг (аймгийн музей ба 18 сумын ОНСТ) | 1,029,359,750 |
| 21 | Говьсүмбэр* аймгийн музей | 62,561,225 |
| 22 | Дархан-Уул аймаг (аймгийн музей ба 1 сумын ОНСТ) | 575,091,600 |
| 23 | Дорноговь аймаг (аймгийн музей ба 12 сумын ОНСТ) | 799,423,096 |
| 24 | Дорнод аймаг (аймгийн музей ба 6 сумын ОНСТ) | 1,087,533,340 |
| 25 | Дундговь аймаг (аймгийн музей ба 10 сумын ОНСТ) | 886,156,800 |
| 26 | Завхан аймаг (аймгийн музей ба 21 сумын ОНСТ) | 1,090,212,688 |
| 27 | Орхон аймгийн музей | 657,174,700 |
| 28 | Өвөрхангай аймаг (аймгийн музей ба 17 сумын ОНСТ) | 1,146,431,700 |
| 29 | Өмнөговь аймаг (аймгийн музей ба 13 сумын ОНСТ) | 84,016,200 |
| 30 | Сүхбаатар аймаг (аймгийн музей ба 3 сумын ОНСТ) | 1,122,103,200 |
| 31 | Сэлэнгэ аймаг (аймгийн музей ба сумын 18 ОНСТ) | 2.286.294.410 |
| 32 | Төв аймаг (аймгийн музей ба 28сумын ОНСТ) | 1,264,192,180 |
| 33 | Увс аймаг (аймгийн музей ба 17 сумын ОНСТ) | 3,451,352,100 |
| 34 | Ховд аймаг (аймгийн музей ба 13 сумын ОНСТ) | 1,261,369,630 |
| 35 | Хөвсгөл аймаг (аймгийн музей ба 15 сумын ОНСТ) | 1,008,983,100 |
| 36 | Хэнтий аймаг (аймгийн музей ба 12 сумын ОНСТ) | 1,128,370,966 |
| 37 | ЭрдэнэЗуу музей (Өвөрхангай аймаг) | 7,305,931,900 |
| 38 | Ялалт музей (Дорнод аймаг) | 85,138,300 |
| | **НИЙТ ҮНЭ** | **105,659,865,196** |

- ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн
- Монголбанкны Эрдэнэсийн сан
- МУИС-ийн НШУСургууль
- ШУТИС-ийн БУХСургууль
- Улаанбаатар Их сургууль
- Говьсүмбэр аймгийн Баянтал сумын ОНСТ
- Шанхын Баруун хүрээ
- Төвхөн хийд зэрэг 8 газар бүртгэлийн үнэ хийгдээгүй байна.

СОЁЛЫН ӨВИЙН




- Түүхийн холбогдолтой цуглуулга -29%
- Шашин шүтлэгийн холбогдолтой зүйл -22%
- Угсаатны зүйн цуглуулга-16%
- Байгалийн түүхийн холбогдолтой -13%
- Урлаг, уран сайхны холбогдолтой-13 %
- Археологийн олдвор7%-ийг тус тус эзэлж байна.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# СОЁЛЫН ӨВИЙН УЛСЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН 2020 ОНЫ БАЯЖИЛТИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

## ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛ

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2020 оны тайлангийн тоон дүнгээр нийт 88 байгууллага 1774 дэсийн 3147 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлээр сан хөмрөгөө баяжуулжээ.

| Хамрагдсан байгууллага | Тоо |
|---|---|
| Улсын музей | 5 |
| Байгууллагын музей /Монголбанкны Эрдэнэсийн сан, Монгол цэргийн музей/ | 2 |
| Эрдэм шинжилгээний байгууллага /ШУА-ийн Археологийн хүрээлэн, Түүх, угсаатны зүйн хүрээлэн/ | 2 |
| Их сургуулийн дэргэдэх музей, лаборатори /Улаанбаатар Их сургууль, Ховд их сургууль/ | 2 |
| Аймаг, орон нутаг, нийслэлийн музей | 20 |
| Сум, дүүргийн ОНСТ /аймгийн хийд-1/ | 57 |
| **Нийт** | **88** |

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

2020 онд баяжилтаар нэмэгдсэн 1774 дэсийн 3147 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлээс **966** дэсийн **1422** ширхэг үзмэрт зааврын дагуу “хувийн дугаар” олгож, “Register” бүртгэлийн программд бүртгэж баталгаажуулсан байна.

| Хамрагдсан байгууллага | Баяжилтаар нэмэгдсэн үзмэр, эд өлгийн зүйл | | Register программд бүртгэгдсэн үзмэр | |
|---|---|---|---|---|
| | дэс | тоо/ш | дэс | тоо/ш |
| Улсын музей | 363 | 580 | 363 | 580 |
| Байгууллагын музей /Монголбанкны Эрдэнэсийн сан, Монгол цэргийн музей/ | 10 | 10 | 3 | 3 |
| Эрдэм шинжилгээний байгууллага /ШУА-ийн Археологийн хүрээлэн, Түүх, угсаатны зүйн хүрээлэн/ | 374 | 1039 | - | - |
| Их сургуулийн дэргэдэх музей, лаборатори /Улаанбаатар Их сургууль, Ховд их сургууль/ | 150 | 186 | - | - |
| Аймаг, орон нутаг, нийслэлийн музей | 448 | 752 | 362 | 593 |
| Сум, дүүргийн ОНСТ /аймгийн хийд-1/ | 381 | 496 | 238 | 246 |
| Иргэний өмчлөлийн эд өлгийн зүйл /47 иргэн/ | 48 | 84 | | |
| **Нийт** | **1774** | **3147** | **966** | **1422** |

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# “Register” бүртгэлийн программд бүртгэгдээгүй 808 дэсийн 1725 ширхэг үзмэрийн тайлбар

| Байгууллагын нэр | Үзмэрийн тоо | | Тайлбар |
|---|---|---|---|
| | дэс | тоо/ш | |
| **Улс, аймгийн музей** | | | |
| **Монгол цэргийн музей** | 5 | 5 | Ерөнхий бүртгэлийн дэвтэртээ бичсэн боловч бүртгэлийн программд оруулаагүй |
| **Сүхбаатар аймгийн музей** | 86 | 159 | Программтай компьютер нь эвдэрсэн /шатсан/ |
| **Монголбанкны Эрдэнэсийн сангийн музей** | 2 | 2 | Тус байгууллага 5 дэсийн 5 ширхэг үзмэрээр баяжилт хийгдсэн боловч 3 дэсийн 3 ширхэг үзмэрийг цахим бүртгэлд оруулсан. |
| **Эрдэм шинжилгээний байгууллага** | | | |
| **ШУА-ийн Археологийн хүрээлэн** | 223 | 643 | Эдгээр байгууллага нь зөвхөн өөрсдийн дотоод данс “Лабораторийн бүртгэл”, “Олдворын бүртгэл”-дээ авч “Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар”-ын дагуу “Хувийн дугаар” өгч Соёлын өвийн бүртгэлийн Register программд оруулаагүй. |
| **ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн** | 151 | 396 | |
| **“Улаанбаатар” Их сургууль** | 134 | 134 | |
| **“Ховд” Их сургууль** | 16 | 52 | |
| **Орон нутаг судлах танхим** | | | |
| **Баянхонгор аймгийн 3 сумын ОНСТ-ын үзмэр** | 4 | 4 | Орон нутаг судлах танхимын үзмэрийг тухайн аймгийн СӨБМСан буюу музей дээр цахим программд оруулдаг боловч эдгээр аймгууд программд оруулаагүй байна. |
| **Дорноговь аймгийн 4 сумын ОНСТ-ын үзмэр** | 10 | 10 | |
| **Дундговь аймгийн 5 сумын ОНСТ-ын үзмэр** | 32 | 32 | |
| **Завхан аймгийн 18 сумын ОНСТ-ын үзмэр** | 79 | 79 | |
| **Шашны байгууллага** | | | |
| **Дундговь аймгийн СӨБМСангаас бүртгэсэн тус аймгийн Дашгэмпилэн хийд** | 18 | 125 | Дундговь аймгийн СӨБМСан тус аймгийн Дашгэмпилэн хийдэд хадгалагдаж буй эд өлгийн зүйлийг шинээр бүртгэж авсан боловч СӨУНБМСангаас шинэ эзэмшигчийн  код аваагүй, Register программд оруулаагүй. |
| **Иргэний эд өлгийн зүйл** | | | |
| **СӨУНБМСанд 2 иргэний эд өлгийн зүйл** | 3 | 3 | Иргэний өмчлөлийн эд өлгийн зүйлийг программд бүртгэх, RCH программын нэмэлт сайжруулалт хийгдэж байна. |
| **Баянхонгор, Өмнөговь, Увс  аймгийн СӨБМСанд 45 иргэний эд өлгийн зүйл** | 45 | 81 | |
| **Нийт** | **808** | **1725** | |

2020 онд баяжилтаар нэмэгдсэн 966 дэсийн 1422 ширхэг үзмэрийг музейд авсан арга замаар нь үзүүлбэл нийт үзмэрийн 61.8%, сумын 26 Орон нутаг судлах танхимд нэмэгдсэн үзмэрийн 99%-ийг “Бэлэг хандив”-аар авсан байна



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

2020 онд баяжилтаар нэмэгдсэн 966 дэсийн 1422 ширхэг үзмэрийг төрөл зүйлээр нь ангилан үзүүлбэл:



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# Шилжилт хөдөлгөөний мэдээлэл

2020 онд төрийн өмчийн 9 музей, эрдэм шинжилгээний 2 байгууллага, аймаг, орон нутгийн 19 музейн нийт 30 байгууллага 2274 дэсийн 3183 ширхэг үзмэр хөдөлгөөнд орсон байна. Үүнээс, Гадаад, дотоодын үзэсгэлэнд болон судалгаанд 2056 дэсийн 2933 ширхэг үзмэр оролцсон, сэргээн засварлалтад 17 байгууллагын 218 дэсийн 250 ширхэг үзмэр хамрагдсан байна. Энэ нь 2019 оныхоос 46%-иар буурчээ.

| Байгууллагын нэр | Дотоодын үзэсгэлэнд оролцсон | | Гадаадын үзэсгэлэнд оролцсон | | Судалгаа, шинжилгээнд хамрагдсан | | Сэргээн засварласан | | Нийт хамрагдсан үзмэр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дэс | тоо/ш | дэс | тоо/ш | дэс | тоо/ш | дэс | тоо/ш | дэс | тоо/ш |
| Улсын музей | 826 | 925 | 19 | 20 | 463 | 809 | 131 | 162 | 1439 | 1916 |
| Эрдэм шинжилгээний байгууллага | 19 | 35 | | | | | 52 | 52 | 71 | 87 |
| Аймаг, орон нутгийн музей | 565 | 918 | | | 164 | 226 | 35 | 36 | 764 | 1180 |
| **Нийт** | **1410** | **1878** | **19** | **20** | **627** | **1035** | **218** | **250** | **2274** | **3183** |

# Харьцуулсан үзүүлэлт

2020 оны СӨУНБМСангийн тайлангийн тоон үзүүлэлтийг
2019 оны СӨУНБМСангийн тайлангийн тоон үзүүлэлтэй харьцуулахад

| 2019 онд баяжилтаар нэмэгдсэн үзмэр, эд өлгийн зүйл | 2020 онд баяжилтаар нэмэгдсэн үзмэр, эд өлгийн зүйл | Харьцуулсан үзүүлэлт /дэсийн дүн/ |
|---|---|---|
| 1410 дэсийн<br>1672 ширхэг | 966 дэсийн<br>1422 ширхэг | **68%<br>БУУРСАН** |
| **2019 онд шилжилт хөдөлгөөнд хамрагдсан үзмэр, эд өлгийн зүйл** | **2020 онд шилжилт хөдөлгөөнд хамрагдсан үзмэр, эд өлгийн зүйл** | **Харьцуулсан үзүүлэлт /дэсийн дүн/** |
| 4901 дэсийн<br>8704 ширхэг | 2274 дэсийн<br>3183 ширхэг | **46%<br>БУУРСАН** |

# СӨУНБМСангийн Register программд бүртгэгдсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тоон дүн /2021.05.01-ны байдлаар/

| Үзүүлэлт | Дэс | Тоо ширхэг |
|---|---|---|
| 2018-2019 оны Улсын тооллогын Register программын дүн | 126810 | 276077 |
| 2019 оны баяжилтаар Register программд нэмж бүртгэгдсэн дүн | 1410 | 1672 |
| 2020 онд баяжилтаар Register программд нэмж бүртгэгдсэн дүн | 966 | 1422 |
| МБШТөв Гандантэгчэнлин хийдийн Register буюу Gandan data-д бүртгэгдсэн дүн | 8333 | 46070 |
| Данзанравжаагийн музейн Register программд бүртгэсэн дүн /хувийн хэвшил/ | 258 | 1461 |
| Олон улсын оюун ухааны музей Register программд бүртгэсэн дүн /хувийн хэвшил/ | 3163 | 9747 |
| **СӨУНБМСангийн Register программд бүртгэгдсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн нийт тоон дүн** | **140940** | **336449** |

## Монгол Улсын Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад бүртгэгдсэн хөдлөх дурсгалт зүйлийн тоон үзүүлэлт (1995-2019)

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн Соёлын өвийн ангилал, зэрэглэлийн 2 бүлгийн 8 дугаар зүйл, Засгийн газрын бүрэн эрхийн тухай 13.1.8 дугаар зүйлд тус тус заасны дагуу Засгийн газрын 18 удаагийн тогтоол шийдвэрээр 778 дурсгалт зүйл хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан.

| д/д | Байгууллага | Түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан Засгийн газрын тогтоолын он, дугаар ба хосгүй үнэт дурсгалт зүйлийн тоо | | | | | | | | | | | | | | | | | | Тухайн байгууллага дахь хосгүй үнэт дурсгалт зүйлийн тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1995 №241 | 1998 №126 | 1999 №110 | 2000 №175 | 2002 №118 | 2003 №124 | 2004 №108 | 2005 №116 | 2006 №144 | 2008 №103 | 2010 №103 | 2011 №214 | 2011 №373 | 2012 №58 | 2012 №105 | 2013 №227 | 2015 №390 | 2019 №360 | |
| 1 | Богд хааны ордон музей | 1 | 49 | | | 19 | | | 3 | | | | 2 | | 1 | | 4 | | | **79** |
| 2 | Чойжин ламын сүм музей | 2 | 7 | | | 3 | | | | | | | | | | 25 | 1 | | | **38** |
| 3 | Дүрслэх урлагийн музей | 25 | 7 | | | 16 | | | 20 | | | | 2 | | | | | 1 | | **71** |
| 4 | Монголын Үндэсний музей | 4 | | | | | 12 | 1 | | | | | 5 | 1 | | | 4 | | | **27** |
| 5 | Монголын Үндэсний номын сан | 6 | | | | 4 | | | | | | | | | | 10 | | | | **20** |
| 6 | ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн | 1 | | | | | | | | | | 25 | | | | | | | | **26** |
| 7 | Байгалийн түүхийн музей | | 8 | | | | | | | | | | | | | | | | | **8** |
| 8 | Монголбанкны Эрдэнэсийн сан | | | 5 | | | | | | | | 15 | | | | | | | | **20** |
| 9 | ШУА-ийн Археологийн хүрээлэн | | | 1 | | | | | | | | 5 | | | | | | | | **6** |
| 10 | МБШТөв Гандантэгчинлэн хийд | | | 13 | | | | | | | | | 2 | | | | | | | **15** |
| 11 | Эрдэнэ Зуу музей | | | | 10 | 7 | | 27 | 15 | | | | 1 | | | 32 | 1 | | | **93** |
| 12 | Өвөрхангай. Шанхын Баруун хүрээ хийд | | | | | | | | | | 15 | | 3 | | | | | | | **18** |
| 13 | Өвөрхангай. Төвхөн хийд | | | | | | | | 1 | | | | | | | | | | | **1** |
| 14 | Дорноговь. Данзанравжаагийн музей | | | | | | | | | 7 | | | | | | | | | | **7** |
| 15 | Төрийн түүхийн музей | | | | | | | | | | | 259 | | | | | | | | **259** |
| 16 | Дундговь. Баруун Чойрын хийд | | | | | | | | | | | | 1 | | | | | | | **1** |
| 17 | Хархорум музей | | | | | | | | | | | | | 60 | | | 3 | | | **63** |
| 18 | Улаанбаатар их сургууль | | | | | | | | | | | | | | | 10 | | | | **10** |
| 19 | Уран зургийн галерей | | | | | | | | | | | | | | | | 5 | | | **5** |
| 20 | Монгол цэргийн музей | | | | | | | | | | | | | | | | 1 | | | **1** |
| 21 | Архангай аймгийн музей | | | | | | | | | | | | | | | | 1 | | | **1** |
| 22 | Говь-Алтай аймгийн музей | | | | | | | | | | | | | | | | 1 | | | **1** |
| 23 | Дорноговь аймгийн музей | | | | | | | | | | | | | | | | 3 | | | **3** |
| 24 | Сүхбаатар аймгийн музей | | | | | | | | | | | | | | | | 2 | | | **2** |
| 25 | Төв аймгийн музей | | | | | | | | | | | | | | | | 1 | | | **1** |
| 26 | Хэнтий аймгийн музей | | | | | | | | | | | | | | | | 1 | | | **1** |
| 27 | ШУА-ийн Түүх, угсаатны хүрээлэн | | | | | | | | | | | | | | | | | | 1 | **1** |
| | Тухайн онд батлагдсан хосгүй үнэт дурсгалт зүйлийн тоо | **39** | **71** | **19** | **10** | **49** | **12** | **28** | **39** | **7** | **15** | **304** | **16** | **61** | **1** | **77** | **28** | **1** | **1** | **778** |

# Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл

- Түүх, соёлын хосгүй үнэт 778 дурсгалт зүйл нь:
  - Төрийн өмчийн 9 музей, эрдэм шинжилгээний 3 хүрээлэн, 1 их сургууль, Үндэсний номын сан, Эрдэнэсийн сан зэрэг 15 байгууллагад - 634 хосгүй үнэт,
  - Орон нутгийн өмчийн 7 музейд – 102 хосгүй үнэт,
  - Шашны өмчийн 4 сүм хийдэд – 35 хосгүй үнэт,
  - Хувийн өмчийн 1 музейд - 7 хосгүй үнэт тус тус бүртгэлтэй хадгалагдаж байна.



# ТҮҮХ, СОЁЛЫН ХОСГҮЙ ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (1995-2019)




- Түүхийн холбогдолтой 403 хосгүй үнэт дурсгалт зүйл (51.7%) (403 хосгүй үнэт дурсгалт зүйлээс 316 ширхэгийг зооснууд эзэлж байна.)
- Шашин шүтлэгийн холбогдолтой 274 хосгүй үнэт дурсгалт зүйл (35.2%),
- Археологийн холбогдолтой 48 хосгүй үнэт дурсгалт зүйл (6.1%),
- Байгалийн өвийн холбогдолтой 34 хосгүй үнэт дурсгалт зүйл (4.3%),
- Урлаг, уран сайхны холбогдолтой 11 хосгүй үнэт дурсгалт зүйл (1.4%),
- Угсаатны зүйн холбогдолтой 8 хосгүй үнэт дурсгалт зүйл (1.02%) тус тус байна

- 2020 оны 12 дугаар сарын байдлаар Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн Соёлын өвийн бүртгэлийн бүрдлийн тухай 21.2.7 дугаар зүйлд заасны дагуу соёлын өвийг дүрс бичлэгээр баримтжуулах ажлын хүрээнд 680 хосүй үнэт дурсгалт зүйл буюу нийт хосгүй үнэт дурсгалт зүйлийн 84,7%-ийг хамруулан дүрс бичлэгээр баримтжуулан, эзэмшигч байгууллагын БМСан болон СӨУНБМСанд бүртгэл, мэдээллийн санд тус тус архивлан хадгалсан байна.



# 5. СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ (СББӨ)-ИЙН БҮРТГЭЛИЙН ТОО БАРИМТ

(Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн тухай 14.1.4 дүгээр зүйл)

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, соёлын сайдын 2019 оны А/759 тоот тушаалаар "Монгол Улсын Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл", "Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл" тус тус батлагдсан.

"Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл"-д соёлын биет бус өвийн 7-н ай савын төрөл зүйлд хамаарах 279 өв, "Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл"-д 7 ай савын 83 өвийн төрөл зүйл, нийт 362 өв хамрагдсан.



# Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл -279 өв

**“Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл**”-д бүртгэгдсэн 279 өвийг 7-н ай савын ангилалд хамаарах өвийн тоо, эзлэх хувиар эрэмбэлвэл:

1. Уламжлалт гар урлал - 77 буюу 28%,
2. Ардын язгуур урлаг - 54 буюу 19%,
3. Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд - 49 буюу 17%,
4. Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам - 44 буюу 16%,
5. Уламжлалт арга ухаан - 39 буюу 14%,
6. Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл - 10 буюу 4%,
7. Мал маллах арга ухаан - 7 буюу 2%-ийг тус тус эзэлж байна.

**Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл** ***/хувиар/***



# Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл-83 өв

“**Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл**”-д бүртгэгдсэн 83 өвийг 7-н ай савын ангилалд хамаарах өвийн тоо, эзлэх хувиар эрэмбэлвэл:

1. Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам -30 буюу 36%,
2. Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд - 22 буюу 27%,
3. Ардын язгуур урлаг - 14 буюу 17%,
4. Уламжлалт технологи, арга ухаан - 6 буюу 7%,
5. Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл - 5 буюу 6%,
6. Уламжлалт гар урлал - 5 буюу 6%,
7. Мал маллах арга ухаан - 1 буюу 1%-ийг тус тус эзэлж байна.

**Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл** ***/хувиар/***



# СББӨ-ийг өвлөн уламжлагчдийн бүртгэлийн тоо баримт

- Соёлын биет бусийн өвийг өвлөн уламжлагчийн тоо 2019 оны суурь түвшингөөс **385** өвлөн уламжлагчаар нэмэгдэж 2020 онд нийт **10849** болж **3.6** хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бол суурь түвшний үзүүлэлтээс 199 хүн “шилжсэн”, “нас барсан”, “шалгуурт тэнцээгүй” гэсэн шалтгаанаар хасагдсаж 2 хувиар буурсан байна.

| № | Аймаг, нийслэл | 2019 оны тоон дүн /суурь түвшин/ | 2020 онд хасагдсан тоо | 2020 онд нэмэгдсэн тоо | Өвлөн уламжлагчийн нийт тоо |
|---|---|---|---|---|---|
| 1 | Архангай | 377 | 19 | | 358 |
| 2 | Баян-Өлгий | 621 | | | 621 |
| 3 | Булган | 185 | 10 | | 175 |
| 4 | Баянхонгор | 311 | 24 | 8 | 295 |
| 5 | Говь-Алтай | 600 | | 49 | 649 |
| 6 | Говьсүмбэр | 319 | 11 | 12 | 320 |
| 7 | Дархан-Уул | 75 | 5 | | 70 |
| 8 | Дорнод | 322 | | 38 | 360 |
| 9 | Дорноговь | 402 | 48 | 67 | 421 |
| 10 | Дундговь | 344 | | 15 | 359 |
| 11 | Завхан | 508 | 16 | 56 | 548 |
| 12 | Орхон | 209 | | 6 | 215 |
| 13 | Өвөрхангай | 262 | | 2 | 264 |
| 14 | Өмнөговь | 305 | | 41 | 346 |
| 15 | Сэлэнгэ | 492 | | | 492 |
| 16 | Сүхбаатар | 253 | 2 | 45 | 296 |
| 17 | Төв | 605 | 112 | | 493 |
| 18 | Увс | 401 | | 19 | 420 |
| 19 | Ховд | 924 | | | 924 |
| 20 | Хөвсгөл | 905 | | | 905 |
| 21 | Хэнтий | 615 | | 88 | 703 |
| 22 | Нийслэл | 1429 | | 186 | 1615 |
| **Нийт** | | **10464** | **199** | **632** | **10849** |

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн анхан шатны бүртгэлийн 2020 оны өсөлт УНБМСанд анхан шатны байдлаар бүртгэгдсэн нийт өвлөн уламжлагчийн тоон дүн.



Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн анхан шатны бүртгэлээс 2020 онд хасагдсан өвлөн уламжлагчийн тоон дүн.



# СББӨ-ийг өвлөн уламжлагчдийн өвлөсөн, эзэмшсэн өвийн хамаарах ай савын үзүүлэлт

Нийт бүртгэгдсэн 10849 өвлөн уламжлагчийг 7-н ай савын ангилалд хамаарах тоо, хувиар эрэмбэлвэл:

1. Ардын язгуур урлаг - 46 % буюу 4187 хүн
2. Уламжлалт гар урлал - 24% буюу 2176 хүн
3. Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам - 9,7 % буюу 881 хүн
4. Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд - 9 % буюу 817 хүн
5. Уламжлалт арга ухаан - 6,2 % буюу 566 хүн
6. Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл - 2,7 % буюу 252 хүн
7. Мал маллах арга ухаан - 1,7 буюу 156 хүн тус тус бүртгэгдсэн байна.



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

## СББӨ-ийг ур чадварын өндөр түвшинд эзэмшсэн өвлөн уламжлагчдийн тоо, харьялах засаг захиргааны үзүүлэлтээр:

Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 475 дугаар тогтоолоор Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшиж “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д бүртгэгдсэн 102 өвлөн уламжлагч иргэн байна.



“Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д бүртгэгдсэн 102 өвлөн уламжлагч иргэнийг СББӨ-ийн 5 ай савын ангиллаар ангилвал:



# ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн өв

- 2008-2019 онд Монгол улс ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад нийт 15 өвийг бүртгүүлж Батламж бичгийг хүлээн авсан.

*ЮНЕСКО-гийн Хүн төрлөхтний СББӨ-ийн төлөөллийн жагсаалтад:*

1. Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг (2008)
2. Монгол ардын уртын дуу (2008, БНХАУ-тай хамтран бүртгүүлсэн)
3. Монгол наадам (2010)
4. Монгол ардын Хөөмэйн урлаг (2010)
5. Шувуулахуй буюу бүргэдээр ан хийх зан үйл (12 улстай хамтран бүртгүүлсэн 2010)
6. Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл (2013)
7. Шагайн харваа (2014)
8. Хөхүүрийн айраг исгэх уламжлал, холбогдох зан үйл (2019)

*ЮНЕСКО-гийн Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад:*

1. Монгол тууль (2009)
2. Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлаг (2009)
3. Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг (2009)
4. Монгол Лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга барил–битүү амьсгаа (2011)
5. Монгол уран бичлэг (2013)
6. Ингэнд ботго авахуулах зан үйл (2015)
7. Уул овоо тахих монгол зан үйл (2017)

# 6. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ:

**Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцооны хүрээнд:**

Соёлын өвийг хамгаалах тухай 20.2 дугаар зүйлд заасны дагуу "Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан" нь аймгийн музейд ажиллаж байгаа бөгөөд музейн БМСанч нь тухайн аймгийнхаа БМСанг соёлын биет ба биет бус 3-н төрлийн өвийн мэдээллийн санг давхар хариуцан ажиллаж байна. Иймд "Аймаг, нийслэлийн БМСан"-гийн үйл ажиллагаа төлөвшүүлэх, чадавхжуулахад хүний нөөцийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага гарч байна. Үүнд:

- 21 аймаг, нийслэлийн БМСангуудад түүх, соёлын үл хөдлөх дурсгал, Соёлын биет бус өв хариуцсан тус бүр 2 хүний орон тоог нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

**Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын орон тоог дараах мэргэжлийн 13 хүний орон тоогоор нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага гарч байна. Үүнд:**

- Соёлын биет бус өвийн 7 ай сав төрөл зүйлийн дагуу эх хэл аман уламжлалын судалгааны чиглэлээр мэргэшсэн 1, ардын язгуур урлагийн чиглэлээр 1, гар урлалын чиглэлээр 1, уламжлалт зан үйлийн чиглэлээр 1, мал маллах арга ухааны чиглэлээр 1, нийт түүх, соёл, угсаатны зүйн чиглэлийн 5 хүний орон тоогоор;
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгал хариуцсан палеонтологийн мэргэжлийн 1, дурсгалт уран барилга архитектурын мэргэжлийн 1, нийт 2 хүний орон тоогоор,
- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хариуцсан угсаатны зүйн мэргэжлийн 1 хүний орон тоогоор,
- СӨУНБМСанд архивч 1, статистикч 1, үл хөдлөх дурсгал, хөдлөх дурсгалт зүйл, соёлын биет бус өв тус бүр хариуцсан бүртгэл, мэдээллийн санч 3, нийт 5 хүнээр орон тоог нэмэгдүүлэх.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

## АНХААРЛАА ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

**Веб сайт: ncch.gov.mn**